



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/83

Улаанбаатар хот

Арга зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.7 дахь заалт, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/692 дугаар тушаал, тус агентлагийн даргын 2025 оны А/226 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус агентлагийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөл, зарим газар, хэлтсийн чиг үүрэг болон албан хаагчдын албан тушаалын нэршил, зэрэглэл өөрчлөгдсөнтэй холбогдуулан Ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын нэгдмэл байдал, стандартыг хангах, техник, технологийн баримт бичгийг шинэчлэх, шинээр боловсруулах, Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын үйл ажиллагаанд мэргэжил, мэргэшлийн зөвлөмж өгөх үүрэг бүхий Арга зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын "Арга зүйн зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай" 2018 оны А/256 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, 2023 оны А/78 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Э. БАТТУЛГА

1525010394

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
2026 оны 04 дугаар сарын 28 ны өдрийн
А/БЗ дугаар тушаалын хавсралт



АРГА ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Зөвлөлийн дарга: Улсын сүлжээний газрын дарга
- Гишүүд:
- Улсын сүлжээний газрын Нислэг, хөдөө аж ахуйн цаг уурын улсын сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Улсын сүлжээний газрын Ус судлалын улсын сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Улсын сүлжээний газрын Цахим сүлжээ, кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Улсын сүлжээний газрын Хэмжих хэрэгсэл, хэмжил зүй, радарын сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Технологи, инновацын хэлтсийн Цаг уурын салбарын технологи, инновац хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Технологи, инновацын хэлтсийн Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Технологи, инновацын хэлтсийн Мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтан
 - Урьдчилан мэдээлэх газрын Урьдчилан мэдээлэх хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Архив, мэдээллийн сангийн хэлтсийн Мэдээллийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Уур амьсгалын өөрчлөлт, орчны шинжилгээний хэлтсийн Орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Уур амьсгалын өөрчлөлт, орчны шинжилгээний хэлтсийн Агаарын чанарын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Урьдчилан мэдээлэх газрын Орон нутгийн урьдчилан мэдээлэх үйлчилгээ хариуцсан ерөнхий инженер
 - Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн Уур амьсгалын өөрчлөлт, нөөцийн судалгааны хэлтсийн дарга
 - Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн Хөдөө аж ахуйн цаг уурын судалгааны хэлтсийн дарга
 - Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн Гадаргын усны судалгааны хэлтсийн дарга

Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн Хиймэл оюун ухаан, тоон загварчлалын судалгааны хэлтсийн дарга

Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга

Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн Хэмжил зүйн хэлтсийн дарга

Нислэгийн цаг уурын төвийн Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Цаг уурын улсын сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн

----oOo----